



ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ 2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар
холбоо барина уу:

Үндэсний аудитын газрын харьяа Төв
аймгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582
И-мэйл

СТА-ын ахлах аудитор
Ц.Базарсад
Утас: 70272287
И-мэйл Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	4
• Залруулаагүй алдаа	6
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	6
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	6
• Аудитын санал дүгнэлт	7

ЭМТөвийн 2013 оны санхүүгийн тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид ЭМТөвийн 2013 оны санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба ЭМТөвийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцогт сумын ЭМТөвийн тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. Байгууллагын дотоод хяналтын бүрэлдэхүүнийг байгууллагын даргын тушаалаар томилж, Дотоод хяналтын журам боловсруулж, батлаагүйгээс энэ талын хяналт хийгдээгүй байна
2. Аймгийн МХГазрын төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт 2014 оны 1-р сард хийгдсэн тул хяналт шалгалт аудитыг санхүүгийн тайлан, журналд түшиглэн анхан шатны баримтыг үзээгүй болно.
3. Цалингийн зардлын бичилт нэг бүрийг цалингийн шатлал, зэрэглэл зэргийг нэг бүрчилэн шалгахад зөрчил илэрсэнгүй. Харин цалингийн сангаас зориулалт бусаар ахмадын санд 225,0 мянган төгрөгийг олгосон байна.
4. ЭМТөвийн эрхлэгчийн тушаалаар тооллогын комиссыг томилон, тооллогын комисс тооллого хийж, тооллогын дүнгийн талаар илтгэх хуудас тайлан бичиж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл үйлдсэн байна. Жилийн эцсийн тооллогыг хүн

- бүрээр хийж эд хөрөнгийг картласан байна.
5. Тайлант онд 41.89 тн буюу 3134.7 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 147 тн буюу 11760,0 мянган төгрөгийн нүүрс бэлтгэж 147 тн буюу 11545,9 мянган төгрөгийн нүүрс зарцуулж 41 тн буюу 3348.8 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй гарсан байна. Нэг цагт 25 кг хоногт 600 кг жилдээ 145,2 тн зарцуулах нормтой бөгөөд тайлант онд 1,8 тн буюу 144,0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.
 6. Тайлант онд хоолны зардалд 2625,2 мянган төгрөг батлагдснаас 2625,2 мянган төгрөгийн зардлыг тайлант онд 233 хэвтэн эмчлүүлэгч 1821 ор хоногоор хэвтэн эмчлүүлэгсдийн хоолны материалд норм нормативын дагуу зарцуулсан байна.
 7. ТБУСТХуулийн 13.2 “улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”, 17.1.7 “байгууллагын төсвийн санхүүжилтийг үр ашигтай явуулах” гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтыг тус тус зөрчин төсөл хөтөлбөрийн зардлаас 115,0 мянган төгрөгийн архивын хавтас авч үр ашиггүй зориулалт бусаар зарцуулсан байна.
 8. Засгийн газрын 2012 оны 150 тоот тогтоолын 2.10 “Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж шийдвэр гаргана” гэсэн заалтыг зөрчин эрхлэгч Л.Басхүү өөрөө өөртөө тушаал шийдвэр гарган 197,4 мянган төгрөгийн урамшил авсан зөрчил илэрсэн.
 9. Тайлант онд 1466,8 мянган төгрөгийн эм боох материалын эхний үлдэгдэлтэй байсан ба

тайлант онд төсвийн хөрөнгөөр 5409,7 мянган төгрөг, үнэ төлбөргүй 765,5 мянган төгрөгийн эм орлого авч 5970,1 мянган төгрөгийн эмийн зарлага гарч 1672,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

10. Тээвэр шатахууны зардалд 6416,0 мянган төгрөг батлагдснаас 6416,0 мянган төгрөг зарцуулсан. БМ-ын тодоруулгын тайлангаар төсвийн хөрөнгөөр 6898,6, ЭМГазраас үнэ төлбөргүйгээр 54,0 мянган төгрөгийн шатахуун авч 6952,6 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Тайлант онд 291 дуудлагад үйлчилснээс 141 алсын дуудлагад 25412 км зам явж 4465л шатахуун зарцуулсан байна. Шатахууныг норм нормативын дагуу олгож зарцуулалтыг бүрэн тооцсон байна.

Ерөнхий менежерээс ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа
- Ерөнхий Аудитор 2014.03.14-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч Г.Даваасүрэн бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**Үндэсний Аудитын Газрын харьяа Төв
Аймгийн Аудитын Газар**

2014.03.14

Танилцуулга

1. Бид Аймгийн Баянцогт сумын ЭМТөвийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Баянцогт сумын ЭМТөвийн ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баянцогт сумын ЭМТ тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Баянцогт сумын ЭМТөвийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Баянцогт сумын ЭМТөвийн тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Баянцогт сумын ЭМТөвийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

- Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн 6.4-д заасныг үндэслэн “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор баталласан. Энэхүү нийтлэг журмын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах ба тус журамд нийцүүлэн аж ахуйн нэгж байгууллага бүр үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналтын журам”-ыг боловсруулаагүй, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтанг томилон ажиллуулаагүй байна.

2. Орлогын талаар

- Батлагдсан төсвийн санхүүжилтыг 2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад санхүүжилт 19205,0 мянган төгрөгөөр буюу өмнөх оноос 11,4 %-иар өссөн нь цалин өссөнтэй холбоотой байна.
- Орлого санхүүжилтийг мөнгөн харилцахын журналаас SORT FILTER-ийг ашиглан эх үүсвэрийг бүрэн ангилан тусгасныг шалгахад орлого, санхүүжилтийг бүрэн бүртгэсэн байна.

- 2013 оны Батлагдсан төсөв 187437,3 мянган төгрөгийг бүрэн авч, өөрийн орлогоос 364,6 мянган төгрөг нийт 187801,9 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

- Харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн 14082000 тоот дансаар 187437,3 мянган төгрөгийн санхүүжилт, өөрийн орлого 364,6 мянган төгрөг, 187801,9 мянган төгрөгийн зарлага гарч 0 төгрөгийн үлдэгдэлтэйгээр Төрийн сангийн төлөөлөгч баталгаажуулсан байна.
- Харилцахын баримтын бүрдэлийг шалгахад анхан шатны баримтын бүрдэлт сайн байна. Сар бүрийн мэдээг программ хангамжаар гаргаж байгааг хяналтын түвшингийн хуулгатай тулган шалгахад сарын мэдээндээ байгууллагын өр, авлагыг тогтмол тулгаж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

4. Бараа материалын талаар

- Бараа материалын тайлангаар тайлант онд БМ-ын эхний үлдэгдэл 21349,6 мянган төгрөг төсвийн хөрөнгөөр 30024,4 мянган төгрөг, хандиваар 1494,5 мянган төгрөг бүгд 31519,0 мянган төгрөгийн орлого нэмэгдэж, 30416,7 мянган төгрөг зарцуулж 1134,3 мянган төгрөгний бараа материалыг сумын ИТХТ-ийн 2013.08.29-ны 66 тоот тогтоолоор акталж устгасан байна.
- Бараа материалын үлдэгдэл, санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэл, тодруулгын тайлангийн үлдэгдлийг тулган шалгахад зөрүү гараагүй.
- Бараа материалын тооллогыг цаг хугацаанд хуулийн дагуу хийж гүйцэтгэсэн байна. Бараа материалын үлдэгдэл няравын материалын үлдэгдэлтэй зөрүүгүй таарч байна.

5. Үндсэн хөрөнгийн талаар

- ЭМТөвийн эрхлэгчийн тушаалаар тооллогын комиссыг томилон, тооллогын комисс тооллого хийж тооллогын дүнгийн талаар илтгэх хуудас өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл үйлдэж баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлж өгсөн байна.
- Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 340831,2 мянган төгрөг, тайлант онд төсвийн хөрөнгөөр 954,7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, данснаас 3118,8 мянган төгрөгний хөрөнгө сумын ИТХТ-ийн 2013.08.29-ны 66 тоот тогтоолоор актлагдаж оны эцэст 338667,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Үндсэн хөрөнгийн Элэгдлийн тооцооллыг программаар зөв бодсон байна.

6. Бараа үйлчилгээний зардал

- Бараа үйлчилгээний зардал нь бүрэн зарцуулагдаж төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 34105,2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүний 40,9 хувь буюу 13959,3 мянган төгрөг нь тогтмол зардал эзлэж байна.
- Нүүрсний тооцооллыг тодруулбал:
- Тайлант онд 43 тн буюу 3181,1 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 147 тн буюу 11760,0 мянган төгрөгийн нүүрс бэлтгэж 147 тн буюу 11545,9 мянган төгрөгийн нүүрс зарцуулж 43 тн буюу 3395,2 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй гарсан байна. Нэг цагт 25 кг хоногт 600 кг жилдээ 145,2 тн зарцуулах нормтой бөгөөд тайлант онд 1,8 тн буюу 141,3 мянган төгрөгөөр илүү зарцуулсан тул акт бичигдэв.

7. Авлага, өглөгийн талаар

- НДаатгал, Татвар, Холбоо, Эрчим хүчний салбар, ЭМГазар, Петровис ХХК-тай тооцоо нийлж өр, авлагагүйг баталгаажуулсан байна.
- Байгууллагуудын өглөг, авлагын журналыг, харилцахын журнал, бараа материалын тодруулгын тайлангийн орлогуудтай тулган шалгахад зөрүү гараагүй.
- Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтэрийн данстай тулган баталгаажуулсан.

8. Цалингийн талаар

- 2013 онд 7 ортой 23 орон тоогоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсанаас 233 хүн хэвтэн эмчлүүлж удирдах-1, гүйцэтгэх-13, үйлчилгээний-9 нийт 23 оронтой үйл ажиллагаа явуулсан байна.
- Ажилтнуудын цалинг ЗГ-аас гаргасан сүлжээнд нийцүүлэн үнэн зөв тогтоосон, бичигдсэн цалин НББ-ийн журнал, СХТ-ийн тоо дүнтэй тохирсон, цалингаас суутган тооцоо хийж байгаа тооцоолол үнэн зөв хийгдэж байна.
- Засгийн газрын 2012 оны 150 тоот тогтоолын 2.10 “Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж шийдвэр гаргана” гэсэн заалтыг зөрчин эрхлэгч Л.Басхүү өөрөө өөртөө тушаал шийдвэр гарган 197,4 мянган төгрөгийн урамшил авсан зөрчил илэрсэн. Үүнд 2014 оны 1-р сард аймгийн МХГазрын санхүүгийн хяналт шалгалтаар акт бичигдсэн.
- Цалингийн сангийн хэмнэлтээс ахмадын санд 225,0 мянган төгрөг шилжүүлсэн.

9. Эргэлтийн эмийн сан

- 2013 оны эхний үлдэгдэл 6465.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 11228.5 мянган төгрөг, мөнгөн орлого 24822.3 мянган төгрөг, мөнгөн зарлага нь бараа материал авахад 18695.1 мянган төгрөг, эмийн санчийн урамшуулалд 558,0 мянган төгрөг 117,0 мянган төгрөгийн томилолтын зардал, ашиглалтын зардалд буюу принтерийн хор, бар код уншигчийн цаас, жижиг эд хогшилд 236,0 мянган төгрөг, шатахуунд 385.5 мянган төгрөг, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн 68,2 мянган төгрөг тус тус зарцуулж цэвэр мөнгөн гүйлгээний дүн 4898,9 мянган төгрөг байна. Бараа материал худалдан авах зардалд 508,2 мянган төгрөгийн санхүүгийн програм худалдан авсан зардал орсон байна.
- Тайлант оны эхэнд 40,1 мянган төгрөгийн ААМ-ын үлдэгдэлтэй байсан ба 236,0 мянган төгрөгийн материал нэмэгдэж 49,0 мянган төгрөгийн материал зарлага болгож 227,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.
- Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3404,2 мянган төгрөг програм хангамж 508,2 мянган төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 3912,4 мянган төгрөгийн хөрөнгөтэй үүнээс элэгдлийн зардал 625,5 мянган төгрөг цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3286,9 мянган төгрөг байна.
- Тайлангийн авлагын эхний үлдэгдэл 11,4 мянган төгрөг байсан ба жилийн эцсээр авлагагүй тайлагнагдсан байна.
- Тайлант үеийн борлуулалт 24822,3 мянган төгрөг, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 17335,3 мянган төгрөг ерөнхий удирдлагын зардалд 1735,0 мянган төгрөг зарцуулж тайлант үеийн ашиг 5812,2 мянган төгрөг байна.
- Тайлант онд эмийн эхний үлдэгдэл 4611,2 мянган төгрөг нэмэгдсэн нь 25801,9 мянган төгрөг худалдсан нь 24810,5 мянган төгрөг 5602,6 мянган төгрөгийн эмийн үлдэгдэлтэй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 9 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ЗГазрын 2011.11.09-ний 311 тоот тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг боловсруулан мөрдөж байгууллагын дотоод хяналтын багийг томилон ажиллуулах
- Төсвийн бүрдүүлэлт зарцуулалтанд төсвийн тухай хуулийг баримтлаж ажиллах

6. Эдгээр асуудлуудыг ААГ болон Баянцогт сумын ЭМТөв авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд ЭМТөвийн удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

10. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Үндэсний Аудитын Газрын харьяа Төв аймгийн Аудитын Газар
2014.03.14